



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ХҮРЭЭМАРАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 15 өдөр

Дугаар 144

Дэлгэрмөрөн

“Шилдэг гудамж-Шилдэг хашаа”
шалгаруулах аян зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Монгол улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.2, 17 дугаар зүйлийн 17.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сум байгуулагдсаны түүхт 100-н жилийн ойг угтан сумын өнгө үзэмжийг сайжруулах зорилгоор сумын төвийн хашаа, гудамж, хорооллыг нэг стандартад оруулж цэгцлэх ерөнхий ажлын хэсгийг дор дурдсанаар байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: С.Нархүү (Тамгын газрын дарга)

Гишүүдэд: Б.Ууганбаяр (Сургуулийн захирал)

Я.Оюунчимэг (Цэцэрлэгийн эрхлэгч)

С.Батхолбоо (Соёлын төвийн эрхлэгч)

М.Дорждагва (Эрүүл мэндийн төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Д.Содномдаржаа (Газрын даамал)

С.Очирбат (Дэлгэр мөрөн 5 дугаар багийн Засаг дарга)

2.Шилдэг хашаа, гудамж, хороолол шалгаруулах журмыг хавсралтаар баталсугай.

3.Хашаа, гудамж, хорооллыг төрийн албан хаагчдад хуваарилан өгч, нэг загвар стандартад оруулж 2022 оны 06 дугаар сарын 03-ний өдрөөс, 08 дугаар сарын 30-ний хооронд зохион байгуулан ажиллахыг ажлын хэсгийнхэнд үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажлын дүн мэдээг Засаг даргын зөвлөлд танилцуулахыг Засаг даргын орлогч (Д.Баярсайхан)-д даалгасугай.

ДАРГА




С.СУМЪЯАБАЗАР

D /bichig hereg/ Zahiramj -2022 on

642201083

Сумын Засаг даргын 2022 оны 06 сарын 11-ний өдрийн 144 тоот захирамжийн хавсралт



**“ШИНЭ ГУДАМЖ-ШИЛДЭГ ХАШАА”
ШАЛГАРУУЛАХ АЯНЫ ЖУРАМ**

НЭГ. АЯНЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮНДЭСЛЭЛ

Монгол улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т “Монгол улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй”, 17 дугаар зүйлийн 17.2-т “Хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалах, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, байгаль орчноо хамгаалах нь иргэн бүрийн журамт үүрэг мөн” гэж тус тус заасан бөгөөд аймгийн “Хүн амьдрах таатай орчинтой” “Ногоон хөгжлийн загвар” аймаг болохоор дэвшүүлсэн зорилт, сум үүсгэн байгуулагдсаны 100 жилийн ойг угтсан арга хэмжээ зэрэг нь энэхүү аяныг зохион байгуулж явуулах үндэслэл болно.

ХОЁР. ЗОРИЛГО

Хүрээмарал сумын иргэдийн оролцоог идэвхжүүлэх, гудамжны эмх цэгц, хашааны өнгө үзэмжийг сайжруулах, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг нь бүрдүүлэхэд энэхүү аяны зорилго оршино.

ГУРАВ. АЯНЫ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Аяныг зохион байгуулах, удирдан чиглүүлэх ажлын хэсгийг сумын Засаг даргын захирамжаар томилж, салбар ажлын хэсэг, бүлгийг албан байгууллага болон багийн Засаг дарга нар зохион байгуулан ажиллуулна.

ДӨРӨВ. АЯНЫ ХАМРАХ ХҮРЭЭ

Хүрээмарал сумын төвд хашаатай айл өрх, албан хаагчдад зохион байгуулна.

ТАВ. АЯНЫ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА

Аяныг 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдрөөс 08 дугаар сарын 30-ны хооронд зохион байгуулна.

ЗУРГАА. АЯНЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХАД ОРОЛЦОХ ОРОЛЦОО

Аяныг зохион байгуулахад Сумын Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэг удирдан чиглүүлэх бөгөөд төсвийн байгууллага, багийн Засаг дарга нар, багийн иргэд, Нийгмийн ажилтан, Төрийн бус байгууллагууд голлон оролцохоос гадна бусад хамтрагч байгууллагуудын оролцоо, дэмжлэгийг авч ажиллана.

ЗУРГАА. АЯНЫ ХҮРЭЭНД ХИЙГДЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Айл өрхүүдэд чиглэсэн орчны эрүүл мэнд, эрүүл ахуй, халдварт өвчнөөс сэргийлэхэд чиглэсэн сургалтуудыг зохион байгуулна. **/Эрүүл мэндийн төв /**

Эрүүл мэндийг дэмжигч өрх гэр бүлийг бий болгох арга зүйн сургалтууд зохион байгуулах. **/Эрүүл мэндийн төв /**

Иргэдийн дунд сайн дурын бүлэг байгуулах, хариуцан ажиллах ажилтан, сайн дурын зөвлөгч ажиллуулах, түүнийг сургаж, туршлагажуулах. **/Байгууллагын дарга нар, 5-р багийн Засаг дарга /**

Сумын гудамжнуудын цэгцлэлт хийж, муруй, догол хэсгийг тэгшилж эгц, шулуун гудамж үүсгэнэ. **/Газрын даамал /**

Гудамжнуудын хашааны өнгө үзэмжийг сайжруулж нэгэн загвар хээ, зосоор өнгөлж үзэмжийг сайжруулна. **/Хариуцсан төрийн албан хаагч нар/**

Иргэдэд нийгмийн сайн сайхныг бүтээх, хамтран ажиллах чиглэлээр олон талт үйл ажиллагааг идэвхжүүлэх. **/Нийгмийн бодлогын мэргэжилтэн /**

Гудамж, өрхийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, шинээр бий болгох хөдөлгөөн өрнүүлэх. **/ Байгаль хамгаалагч нар /**

Аяны хүрээнд санаачлагатай, бүтээлчээр идэвхитэй оролцсон байгууллага, гудамж, өрхүүдийн үйл ажиллагааг урамшуулах, болзолт уралдаан зарлаж дүгнэх. **/ Удирдлагын баг, ажлын хэсэг/**

ДОЛОО. АЯНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

7.1 Аяны хүрээнд санаачлагатай, бүтээлч, идэвхтэй оролцсон “ШИНЭ ГУДАМЖ-ШИЛДЭГ ХАШАА”-ны шалгуур үзүүлэлт

- Тухайн хашаа нь дотроо цэвэр, тохилог өнгө үзэмжтэй орчныг бүрдүүлсэн байх
 - Хашаандаа хүрээ, хээ хадаж, зосдож тэгшилсэн байх
 - Хашааны том, жижиг хаалгаа стандартын дагуу жигд хийж, будаж тэгшилсэн байх
 - Хашаагаа стандартын дагуу хаягжуулсан байх
 - Хашаандаа шинээр мод тарьж ургуулсан, ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн байх
 - Хашаандаа гэрэлтүүлэгтэй байх
 - Стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай болж, ариутгалыг тогтмол хийлгэсэн байх

- Хэрвээ нохойтой бол хашааны хаалган дээр харагдахуйц тодорхой анхааруулга байрлуулж, тусгай байр, уяатай байх

7.2. Шилдэг тэргүүний “ШИНЭ ГУДАМЖ-ШИЛДЭГ ХАШАА” гудамжны шалгуур үзүүлэлт

- Нийт хашаагаа тэгшилж нэг эгнээ, шулуун шугамд оруулсан байна.
- Гудамжны зам харгуйг хайрагжуулж тоос шорооноос сэргийлсэн арга хэмжээг авсан байх
- Гудамжны айл өрхүүд нийлж бүлгийн зохион байгуулалтад орсон байх.
- Гудамжны хашааг жигд зостож, шохойдож, хээлсэн байна.
- Гудамжны өмнөх авто замыг тэгшлэх, зорчих хэсгийг саадгүй болгож тэмдэг тэмдэглэгээ хийсэн байх

- Гудамжны ойр орчмын харьяа газрыг цэвэрлэж хоггүй цэвэр байлгах

НАЙМ. АЯНЫ ШАГНАЛЫН САН

8.1.Тэргүүний тохижилт соёлжилттой эрүүл ахуйн стандарт хангасан хашаа

- ✓ Тэргүүн байр-1 Өргөмжлөл 400 000 төгрөг
- ✓ Дэд байр -1 Өргөмжлөл 300 000 төгрөг
- ✓ Гутгаар байр -1 Өргөмжлөл 200 000 төгрөг

8.2.Сумын хэмжээнд аяныг зохион байгуулахад идэвхтэй оролцож тэргүүлсэн гудамж, хороолол

- ✓ Тэргүүн байр -1 Өргөмжлөл 500 000 төгрөг

8.3.Сумын хэмжээнд аяныг зохион байгуулахад идэвхтэй оролцож, хариуцсан хашаа, гудамж, хороололоо бүрэн тохижуулж тэргүүлсэн байгууллага

- ✓ Тэргүүн байр -1 Өргөмжлөл 500 000 төгрөгөөр тус тус шагнаж урамшуулна. Шагналыг Засаг даргын нөөц хөрөнгөөс гардуулна.